Хил хамгаалах ерөнхий газрын 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 41/04 дугаар албан бичгийн хавсралт

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо [1]	Хувийн жин [2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	0.8	8
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	0.7	7
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал]	0.5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.4	4
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	5
Хэсгийн оноо				4	3.4	34
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх (гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	0.8	8
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
Хэсгийн оноо				3	2.8	28
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	0.5	5
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал (Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал		1	0.8	8
Хэсгийн оноо				3	2.3	23
Үнэлгээний нийт оноо, хувь				10	8.5	85

---o0o---

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ ТАЙЛАН

***Нэг.** Товч танилцуулга*

Хил хамгаалах байгууллага нь 1933 онд Дотоодыг хамгаалах газрын харьяа Цэргийн ба Хязгаарын хэлтэс нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1996 оноос Засгийн газрын тохируулагч агентлаг болж, 2000 оноос Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Хил хамгаалах ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хамт олны санал, асуулгаар байгуулагдсан бөгөөд мөн газрын даргын А/120 дугаар тушаалаар баталгаажуулсан.

Хил хамгаалах ерөнхий газрын харьяа 31 хилийн цэргийн анги, тусгай салбарт Ёс зүйн дэд хороо үйл ажиллагаа явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

***Хоёр.** Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар*

***2.1.** Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт*

“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээнээс Хил хамгаалах ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөнд 22 зорилтод арга хэмжээг тусган, хэрэгжүүлсэн. Үүнд:

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолын дагуу Хил хамгаалах байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийг тооцож, ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлтэй гэж үнэлэгдсэн 33 албан хаагчаар ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулж, ёс зүйн зөрчил гаргасан 13 албан хаагчид “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн хуудас” хөтөлж, албажуулсан.

Хил хамгаалах байгууллагад анх ажилд орж буй иргэдийн ёс суртахуун, зан төлөвийн онцлогийг сэтгэл зүйн судалгааны аргачлал ашиглан тодорхойлж, сонгон шалгаруулалтад хамруулсан.

Хил хамгаалах байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын, цэргийн академийн, бусад сургалтын 17 удаагийн сонгон шалгаруулалтад Ёс зүйн дэд хорооны гишүүд оролцож, ёс зүй, сахилга хариуцлагын байдалд үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан.

Хил хамгаалах ерөнхий газарт томилогдсон 25 албан хаагчид чиглүүлэх сургалтыг зохион байгуулж, албан тушаал дэвших, шагнаж урамшуулахад ёс зүй, сахилга хариуцлагын байдлыг харгалзан үзэж, мерит зарчим баримтлан ажилласан.

Судалгаа шинжилгээний үр дүнд суурилсан ёс зүйн үнэлгээг чанаржуулах зорилтын хүрээнд “Хилчдийн сэтгэл зүйд дүн шинжилгээ хийх нь” судалгааны ажлыг зохион байгуулж, судалгааны үр дүнг үндэслэн зөвлөмж боловсруулсан.

Байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх, зөрчил, гомдол, мэдээллийг хүлээн авах 94343499 тусгай дугаарыг ажиллуулсан.

Хил хамгаалах байгууллагын гадаад орчноос тусгаарлагдсан, бие даасан дотоод сүлжээ, албаны (BMS) программыг ашиглан ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх 48 цагийн цахим сургалтыг зохион байгуулсан.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2025 оны А/275 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг олгосон.

Хил хамгаалах ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны сул гишүүний оронд хамт олноос 2 удаа санал асуулга авч, сонгогдсон гишүүдийн нэрсийг 2025 оны А/16, А/274 дүгээр тушаалаар баталгаажуулсан.

Хил хамгаалах байгууллагын бүтэц, зохион байгуулалтын онцлогтой уялдуулан хилийн цэргийн анги, тусгай салбарын захирагч, орлогч нарын ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Хил хамгаалах ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд харьяалуулан, хянан шалгаж, дүгнэлт гаргах чиглэлийг 2025 оны А/51 дүгээр тушаалаар баталгаажуулсан.


Ёс зүйн дэд хорооны дүгнэлтээр ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон 2 алба хаагчид Хил хамгаалах ерөнхий газрын даргын, 8 алба хаагчид ангийн захирагчийн тушаалаар ёс зүйн хариуцлага ногдуулсан ба 3 алба хаагчид Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасан сайн дурааараа хариуцлага хүлээх боломж олгосон.


2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

Ёс зүйн зөрчлийн гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, дүнг хэлэлцэх зорилгоор Хил хамгаалах ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо 10 удаа, хилийн цэргийн анги, тусгай салбарын Ёс зүйн дэд хороо 8 удаа хуралдаан зохион байгуулж, 18 дүгнэлт гарган, томилох эрх бүхий албан тушаалтанд танилцуулсан.

Хил хамгаалах ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо нь харьяалах бүтцийн нэгж болон хилийн цэргийн анги, тусгай салбарт 4 удаа зөвлөмж өгч, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Ёс зүйн дэд хороо 2025 онд 18 ёс зүйн зөрчлийн гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шалгасан ба 13 гомдол, мэдээлэл тогтоогдож, 5 гомдол, мэдээлэл тогтоогдоогүй.





Хилийн цэргийн анги, тусгай салбаруудын Ёс зүйн дэд хороонд 24 удаа ёс зүй, сахилга хариуцлагыг бэхжүүлэх чиглэлээр мэдээлэл, чиглэл өгч, давхардсан тоогоор 4577 албан хаагчдад ёс зүйг төлөвшүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн сургалтыг зохион байгуулсан.

Ёс зүйн дэд хорооны хуралдааны тэмдэглэл, дүгнэлтийн хэвлэмэл хуудсыг хэвлүүлж, үйл ажиллагаанд ашиглаж байна.

Ёс зүйн дэд хорооны гишүүдэд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг танилцуулж, баталгаа гаргуулсан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Хил хамгаалах байгууллагын албан хаагчдаас ирүүлсэн нийт 18 гомдол, мэдээллийг хуулийн хүрээнд хянан шалгаж, дүгнэлт гарган албажуулсан.	Харьяа байгууллагын ёс зүйн дэд хороог удирдах, үүрэг, чиглэл өгөх, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх асуудлыг хууль, журмаар зохицуулаагүй.
Санал: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-д харьяа байгууллагын ёс зүйн дэд хороог удирдах, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх талаар нарийвчлан тусгах.	

Шалгах хэсэг:

-“Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

-Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

-Байгууллагын 2025 оны “Ёс зүйн дэд хороо”-ны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:
ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Ж.БЯМБАСҮРЭН

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА,
ХУРАНДАА Ц.МЯГМАРДОРЖ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА Ж.ЦОЛМОН

Огноо 2025 оны 01 сарын 02.

БАТЛАВ
ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД
ХОРООНЫ ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Д.МӨНГӨНЖИН
2025 оны 02 дугаар сарын 13

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”, “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг тус тус хэрэгжүүлэхэд оршино.

2025 оны 02 дугаар сарын 13 Улаанбаатар хот

д/д	Зорилт, арга хэмжээ	Хугацаа	Төсвийн зардал (сая, төгрөг)	Хариуцах албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэх албан тушаалтан
1	2	3	4	5	6
Нэг.Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:					
1	Хил хамгаалах ерөнхий газрын ёс зүйн дэд хорооны сул гишүүний оронд хамт олноос санал асуулга авч, сонгогдсон гишүүний нэрийг баталгаажуулах	II/01	Төсөв шаардахгүй	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Хурандаа Ж.Цолмон
2	Монгол Улсын Их хурлаар 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу 2025 онд дэд хорооны гишүүдэд урамшуулал олгох эсэх талаар Ёс зүйн хорооноос чиглэл, мэдээлэл авах	II сар	Төсөв шаардахгүй	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Хурандаа Ж.Цолмон
3	Хилийн цэргийн анги, тусгай салбаруудын ёс зүйн дэд хорооны гишүүдтэй цахим хурал зохион байгуулж, мэдээлэл, чиглэл өгч, мэргэжлийн удирдлагаар хангах	Сар бүр сүүлийн 7 хоногт	Төсөв шаардахгүй	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Дэд хорооны гишүүд

Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг таниулах, сурталчлах, соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр:					
Хил хамгаалах ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулах арга хэмжээ:					
4	"Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийн дагуу урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн аян зохион байгуулах, контент бэлтгэх	Улирал бүр	Үйл ажиллагааны зардлаас	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Дэд хорооны гишүүд
5	Хилийн цэргийн анги, тусгай салбарын Захиргаа, хүний нөөцийн тасгийн дарга нарт Төрийн албан хаагчийн ёс зүй талаар сургалт орох	II сар	Төсөв шаардахгүй	Хурандаа Ж.Цолмон	Дэд хурандаа Н.Сүх-Очир
6	Хил хамгаалах ерөнхий газарт томилогдсон болон шинээр ажилд орсон алба хаагч нарт чиглүүлэх сургалт зохион байгуулах	Сар тутам	Төсөв шаардахгүй	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Дэд хурандаа Н.Сүх-Очир
7	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг бие бүрэлдэхүүнд хүргэх, сурталчлах зорилгоор контент бэлтгэх	Улирал бүр	Үйл ажиллагааны зардлаас	Хурандаа П.Батбилэг	Дэд хорооны гишүүд
Ёс зүйн хорооноос зохион байгуулах арга хэмжээ:					
8	Төрийн албаны салбар зөвлөлөөс Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтуудыг зохион байгуулах	Хагас жил тутам	Төсөв шаардахгүй	Хурандаа П.Батбилэг	Дэд хурандаа Н.Сүх-Очир
9	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчилах, бие бүрэлдэхүүний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд хилийн цэргийн анги, тусгай салбаруудаас тус бүр нэг албан хаагчийг сургагч багшаар бэлтгэх цахим сургалт зохион байгуулах	04 дүгээр сард	Үйл ажиллагааны зардлаас	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Дэд хурандаа Н.Сүх-Очир
10	Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын сургалтад ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг хамруулах	II сар	Төсөв шаардахгүй	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Дэд хурандаа Н.Сүх-Очир
11	Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтад Хил хамгаалах ерөнхий газар, хилийн цэргийн анги, тусгай салбарын удирдах бүрэлдэхүүнийг хамруулах	Тухай бүр	Төсөв шаардахгүй	Хурандаа П.Батбилэг	Дэд хурандаа Н.Сүх-Очир

Гурав. Үүсч болзошгүй ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэл тооцох, дүн шинжилгээ хийх ажлын чиглэлээр:					
12	Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын 2024 оны ёс зүйн зөрчлийн судалгааг боловсруулах	II/28-ны дотор	Төсөв шаардахгүй	Хурандаа Ш.Баатарсүх	Хурандаа Ж.Цолмон
13	Алба хаагчдын ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээг авах	Жилийн хугацаанд	Төсөв шаардахгүй	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Дэд хорооны гишүүд
14	Чиглэлийн бүтцийн нэгжтэй хамтран ёс зүйн зөрчлийн судалгаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эрсдэлийг тодорхойлох арга хэмжээг авах	VI/30-ны дотор	Төсөв шаардахгүй	Хурандаа Ш.Баатарсүх	Хурандаа Ж.Цолмон
15	Ёс зүйн дэд хорооны гишүүдэд холбогдох хууль тогтоомжийг танилцуулж, нууцын баталгаа авах	II/28-ны дотор	Төсөв шаардахгүй	Хурандаа Ш.Баатарсүх	Хурандаа Ж.Цолмон
16	Хилийн цэргийн анги, тусгай салбаруудын ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдад ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэхэд хяналт тавих	Жилийн хугацаанд	Төсөв шаардахгүй	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Дэд хорооны гишүүд
Дөрөв.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын чиглэлээр:					
17	Иргэд, албан хаагчдын өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт хийх	Тухай бүр	Төсөв шаардахгүй	Хурандаа Ц.Мягмардорж	Дэд хурандаа Ч.Мягмарбаяр
18	Төрийн байгууллагын хүнд суртал, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2024 оны 825 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Сар тутам	Төсөв шаардахгүй	Хурандаа Ц.Мягмардорж	Дэд хурандаа Ч.Мягмарбаяр
19	Ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх, дүгнэлт гаргах, шаардлагатай судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг боловсруулах чиглэлээр холбогдох байгууллагаас зөвлөгөө, мэдээлэл авах ажлыг зохион байгуулах	Эхний хагас жилд	Төсөв шаардахгүй	Хурандаа Ц.Мягмардорж	Дэд хурандаа Ч.Мягмарбаяр
Тав.Гомдол, мэдээлэл хүлээн авах, хянан шийдвэрлэх ажлын чиглэлээр:					
20	Ёс зүйн дэд хорооны даргын шийдвэрийн дагуу гишүүдэд гомдол, мэдээллийг хуваарилж, хэрэгжилтийг хангуулах	Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаас	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Дэд хорооны гишүүд

21	Ёс зүйн дэд хорооны хуралдааны үед гишүүдийг үүрэгт ажлаас нь түр чөлөөлж, хуралдааны ирцийг хангуулах арга хэмжээг авах	Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаас	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Хурандаа Ж.Цолмон
22	Байгууллагын алба хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж, Ёс зүйн хороонд хүргүүлэх	Хуулийн хугацаанд	Төсөв шаардахгүй	Бригадын генерал Д.Мөнгөнжин	Хурандаа Ж.Цолмон
Нийт 5 үйл ажиллагааны чиглэлээр 22 арга хэмжээ төлөвлөсөн.					

ТӨЛӨВЛӨСӨН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ГИШҮҮН,
ХУРАНДАА Ш.БААТАРСҮХ

ХУРАНДАА Ц.МЯГМАРДОРЖ

ХУРАНДАА П.БАТБИЛЭГ

ДЭД ХУРАНДАА Н.СҮХ-ОЧИР

ДЭД ХУРАНДАА Ч.МЯГМАРБАЯР

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА Ж.ЦОЛМОН